



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 11 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 11 дүгээр хуралдаан 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 11 дүгээр хуралдаанаар /2025-05-14/ ХХЗХ-ны 2025 оны ээлжит 09 дүгээр хуралдааны 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн “Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай” (“Радио давтамжийн 3300-3400 МГц, 3500-4000 МГц-ийн зурвасыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”) Хорооны баталсан 2025 оны 102 тоот тогтоолын хэрэгжилтийн тухай асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 1 (Тогтоол №114, 2025-05-14) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 10 дугаар хуралдаанаас (2025-05-09) Үнэлгээний ажлын хэсэгт батлагдсан 2025 оны 102 тоот тогтоолын хэрэгжилтийг хугацаанд хэрэгжүүлэх удирдамж, чиглэл өгч, Ондо ХХК-д тогтоолын 2 дугаар заалт (Шалгарсан оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулж, холбогдох саналыг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд ажлын 3 хоногийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэгт даалгасугай), 3 дугаар заалт (Радио давтамжийн зурвасыг 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн 12:00 цагт сонгохыг эрэмблэгдсэн Ондо ХХК-д мэдэгдсүгэй)-ын дагуу заасан хугацаанд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 2025 оны 102 тоот тогтоолын хэрэгжилтийг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг Үнэлгээний ажлын хэсэг, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга Т.Наранмандах-д тус тус даалгасан болно. Энэхүү тогтоолын заалт, тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээг Үнэлгээний хэсгээс 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөрт багтаан зохион байгуулан ажиллажээ. Үүнд: Ондо ХХК-иас өдөр ирүүлсэн “Мэдэгдэл хүргүүлэх тухай” албан тоот (2025-05-09)-оор тус компанийн зүгээс радио давтамжийн сонголтыг 2025-05-13-ны өдрийн дотор хийх мэдэгдэлийг хүлээн авсан. Улмаар тус компанийн гүйцэтгэх захирал Б.Мандуул 2025-05-13 өдрийн 16:38 цагт радио давтамжийг сонгон баталгаажуулсан болно. Иймээс ХХЗХ-ны 2025 оны ээлжит 11 дүгээр хуралдаанд Үнэлгээний ажлын хэсгээс зохицуулах хорооны баталсан 2025 оны 102 тоот тогтоолыг хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, холбогдох танилцуулга, шалгарсан Ондо ХХК-ийн оролцогчоор радио давтамжийн зурвас сонгуулах үйл ажиллагааг эрэмбийн дагуу зохион байгуулсан радио давтамжийн зурвасын сонголт, тогтоолын төслийг тус тус хэлэлцээд, Хорооны 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 114 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, тус

хорооны 2025 оны 57 дугаар тогтоол, 2025 оны 102 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Хорооны 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 114 тоот “Тусгай зөвшөөрөл олгох тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд, “Ондо ХХК-д Улаанбаатар хот болон 21 аймаг, сум, багийн нутаг дэвсгэрт Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд 3800-3900 МГц-ийн Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс 2030 оны 5 дугаар сарын 14-ний өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай; Ондо ХХК нь тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай; Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай. “ гэж шийдвэрлэсэн.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-05-15